



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ийн 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/97/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Энхдалай

Утас: 51-260512 Цахим хаяг: enkhulalaiid@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Даваадорж

Утас: 51-261628 Цахим хаяг: @audit.gov.mn

Ирмүүн хантайшир аудит ХХК-ийн захирал: Д.Бямбацэрэн

Утас: 77550809 Цахим хаяг: irmuunkhantaishir@gmail.com

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	13
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1. Албан шаардлага	17
5.2. Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БОННУ	Байгаль орчин нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын тайлан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ҮЙЦЭТГЭГЧ Э.ГАНХҮҮ ТАНАА

2026.03.16 № 06/733
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 555.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 111.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй;
- Компани нь өмнөх онд үүссэн 33.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өглөг үүсгэсэн, тайлант хугацаанд 50.0 сая төгрөгөөр өр төлбөрийг нэмэгдүүлсэн.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "толилуулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам,

зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэс оюу толгой ХХК нь "Барилга байгууламж худалдан авах" 20240102005 дугаар бүхий гэрээний дагуу "Би Эм Си Эм" ХХК-аас ITC Tower барилгын 10 давхарт 532.2 м² талбай бүхий, 8,247.0 сая төгрөгийн үнэлгээтэй оффисын талбайг худалдан авч үл хөдлөх хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

"Эрдэнэс оюу толгой" ХХК нь нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний зорилгод нийцүүлэн 2025 онд 7 үндсэн зорилгын хүрээнд 56 зорилт, 130 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж гүйцэтгэл 91.2 хувь гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,970,783,349.78	1,214,651,561.63
1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	-	480,955,241.60
1.1.3.6	ЭМНД-ийн шимтгэлийн тооцоо	5,221,293.38	8,678,123.68
1.1.4	Бусад авлага	-	213,672,272.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,774,105,895.00	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,750,110,538.15	1,917,957,199.64
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	583,318,025.03	7,888,752,831.58
1.2.1.2	Барилга байгууламж	-	7,497,272,727.23
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	-	(93,715,909.10)
1.2.1.6	Тээврийн хэрэгсэл	423,900,000.36	423,900,000.36
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	(50,685,934.81)	(93,075,934.85)
1.2.1.8	Тавилга эд хогшил	170,144,858.71	178,529,503.71
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	(16,315,825.97)	(33,085,028.51)
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	291,995,522.48	291,995,522.48
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	(235,720,595.74)	(283,068,049.74)
1.2.2	Биет бус хөрөнгө	30,477,160.29	26,331,246.43
1.2.2.13	Бусад биет бус хөрөнгө	41,459,148.55	41,459,148.55
1.2.2.14	Хуримтлагдсан элэгдэл. Бусад биет бус хөрөнгө	(10,981,988.26)	(15,127,903.12)
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
1.2.6	Хойшлогдсон татаарын хөрөнгө	-	290,899,168.40
1.2.1	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,748,396,215,185.31	2,755,988,403,245.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,760,146,325,723.47	2,757,906,360,445.05
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3.1	Орлогын татварын тооцоо	512,772,612.59	-
2.1.1.3.4	ХХОАТ-ын тооцоо	50,987,592.03	13,853,179.42
2.1.1.5	Хүүний өглөг	5,648,543,124.54	6,362,644,946.46
2.1.1.10	Байгууллагад өгөх өглөг	33,860,000.00	83,860,000.00
2.1.1.1.1	Хувь хүнд өгөх өглөг	4,715,506.68	4,715,506.68
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,250,878,835.84	6,465,073,632.56
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	6,373,679,430.00	6,373,679,430.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,373,679,430.00	6,373,679,430.00
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	12,624,558,265.84	12,838,753,062.56

Эрдэнэс оюу толгой ХХК- ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3.1	Төрийн өмч	300,000,000.00	300,000,000.00
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	(560,652,642.37)	(3,014,812,617.52)
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	4,018,135,106.74	(2,618,092,515.63)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(4,578,787,649.10)	(396,720,101.88)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,747,621,767,457.63	2,746,067,607,382.48
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,760,146,325,723.47	2,767,906,360,446.06

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,949,406,836.36	1,047,396,804.55
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг /алдагдал/	9,949,406,836.36	1,047,396,804.55
5	Хүүний орлого	139,163,982.84	65,063,049.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,585,263,990.07	3,272,926,670.44
11	Санхүүгийн зардал	714,101,821.92	714,101,821.92
12	Бусад зардал /ҮАБЗ/	279,500,290.00	60,932,713.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(14,054,566.38)	26,509,667.23
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,496,650,160.83	(2,908,991,684.04)
19	Орлогын татварын зардал	477,515,044.08	290,899,168.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,018,135,106.74	2,618,092,515.63
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	4,018,135,106.74	2,618,092,515.63

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-нээр үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(4,355,301,026.91)	2,743,727,118,973.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			119,378,500.00	119,378,500.00
3	Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(4,235,922,528.91)	2,743,846,497,473.09
4	Тайлант үеийн цэвэр ашиг			4,018,135,106.74	4,018,135,106.74
7	Зарласан ногдол ашиг			(342,865,122.20)	(342,865,122.20)
9	2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(560,652,542.36)	2,747,521,767,457.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			163,932,440.48	163,932,440.48
11	Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(396,720,101.88)	2,747,685,699,898.12
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			(2,618,092,515.63)	(2,618,092,515.63)
17	2025 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(3,014,812,617.52)	2,745,067,607,382.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөр дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31-	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	11,063,726,020.00	1,152,136,485.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,944,347,520.00	1,152,136,485.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	119,378,500.00	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	6,798,222,294.53	2,918,891,205.92
1.2.1	Ажилчдад төлсөн	1,517,561,441.00	1,689,118,006.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	504,317,366.54	477,174,537.60
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	39,712,250.45	38,585,474.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	6,727,705.90
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,670,817,544.82	584,511,271.62
1.2.8	Бусад мөнгөн зарлага	65,813,691.72	122,774,210.80
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,265,503,725.47	1,766,754,720.92
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн	158,734,107.20	70,634,149.55
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	19,570,124.36	5,571,100.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	139,163,982.84	65,063,049.55
2.2	Мөнгөн зарлагын дүн	669,086,950.00	96,074,150.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	12,269,600.00	4,772,870.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	646,817,350.00	91,301,280.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-600,352,842.80	-25,440,000.45
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
3.1	Мөнгөн орлогын дүн	13,222,810.91	2,085,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	13,222,810.91	2,085,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	8,440,253,506.18	2,992,531,734.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,097,388,383.98	2,992,531,734.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	342,865,122.20	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-8,427,030,695.27	2,990,446,734.00
4	Валютын ханшийн зөрүү	-14,054,566.38	26,509,667.23
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-4,675,934,378.98	4,756,131,788.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,646,717,728.76	5,970,783,349.78
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,970,783,349.78	1,214,651,561.63

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/м	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2026 гүйцэт
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:								
1	Ажил, үйлчилгээний орлого	м.төг	9,949,406.8	380,000.0	1,138,969.5	(8,949,601.3)	11.3	758,969.5
	Хүүгийн орлого	м.төг	139,164.0	380,000.0	1,047,396.8	(8,902,010.0)	10.5	667,396.8
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	м.төг			65,063.0	(74,100.9)	46.8	65,063.0
2	Нийт орлого	м.төг	10,088,570.8	380,000.0	1,138,969.5	(8,949,601.3)	11.3	758,969.5
3	Нийт зардал	м.төг	5,313,420.4	7,593,636.0	4,047,961.2	(1,265,459.2)	76.2	(3,546,674.8)
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	5,313,420.4	7,593,636.0	4,047,961.2	(1,265,459.2)	76.2	(3,545,674.8)
4	Татварын өмнөх ашиг	м.төг	4,775,150.4	(7,213,636.0)	(2,908,991.7)	(7,684,142.1)	(60.9)	4,304,644.3
	Цэвэр ашиг /аппагдал/	м.төг	4,018,135.1	(7,213,636.0)	(2,618,092.5)	(6,636,227.6)	(65.2)	4,595,543.5
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	1,245,468.5	2,690,049.2	1,783,717.0	538,248.5	143.2	(906,332.2)
	а/ Орлогын татвар	м.төг	477,515.0	354,528.1	354,528.1	(122,987.0)	74.2	-
	б/ НӨТ	м.төг	365,302.4	-	-	(365,302.4)	-	-
	в/ НДШ	м.төг	234,525.5	477,174.5	477,174.5	242,649.0	203.5	-
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	168,011.0	229,534.4	229,534.4	61,523.3	136.6	-
3/	д/ Үп хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-	-	-
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	114.5	722,480.0	722,480.0	722,365.5	630,931.8	-
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	-	906,332.2	-	-	-	(906,332.2)

САГ-2026/97/НА-СТА-ТӨҮГ

Зрдэнэс оюу толгай ХХК-ийн 2025 оны саяхүүлийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	342,865.1	906,332.2	906,332.2	563,467.1	264.3	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	30	31	28	(2)	93.3	(3)	90.3
9	Нийт цалингийн сан	м.төг	1,884,174.3	2,272,452.0	2,087,603.7	203,429.4	110.8	(184,848.3)	91.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	62,805.8	73,304.9	74,557.3	11,751.5	118.7	1,252.4	101.7
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг				-		-	
12	Хөрөнгө оруулалт	м.төг	8,632,750.0			(8,632,750.0)	-	-	
13	Нийт авлага	м.төг	-	-	-	-	-	-	
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	
	Нийт өглөг	м.төг	12,624,568.3	-	12,838,753.1	214,194.8	101.7	12,838,763.1	
14	Богино хугацаат өр төлбөр	м.төг	6,250,878.8	-	6,465,073.6	214,194.8	103.4	6,465,073.6	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	6,373,679.4	-	6,373,679.4	-	100.0	6,373,679.4	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

"Эрдэнэс оюу толгой" ХХК нь Монгол Улсын ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэх Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой ордод үйл ажиллагаа явуулж буй "Оюу толгой" ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх үндсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэс монгол ХХК-ийн охин компани байна.

Компанийн Үндсэн зорилго

Стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой ордод үйл ажиллагаа явуулж буй Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх.

Алсын хараа

Байгалийн баялгийн өгөөжийг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, Үнэ цэнийг бий болгон өсөлт хөгжлөөр тэргүүлнэ.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

"Эрдэнэс оюу толгой ХХК-ийг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 348 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй ...5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тус компанийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалттай нийцэж байна.

Эрдэнэс Оюу толгой ХХК нь Ашигт малтмал түүнтэй холбоотой бусад хуулиуд, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Гадаад хөрөнгө оруулалтын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай, татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Эрдэнэс Оюу толгой ХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод нэгж хэсгийн бүтэц орон тоог өөрчлөн баталж, үйл ажиллагааны журмыг боловсруулан батлуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Эрдэнэс Оюу толгой" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

"Эрдэнэс Оюу толгой" ХХК нь 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн "Эрдэнэс монгол" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 76 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд тус бодлогын баримт бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй болно. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад болон үйл ажиллагааны онцлогт нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс Оюу толгой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,239.6 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31	Өөрчлөлт
Мөнгө хөрөнгө	5,970,783.3	1,214,651.6	(4,756,131.8)
Авлага	5,221.3	703,305.6	698,084.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,774,105.9	-	(5,774,105.9)
Үндсэн хөрөнгө	583,318.0	7,888,752.8	7,305,434.8
Биет бус хөрөнгө	30,477.2	26,331.2	(4,145.9)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420.0	2,747,782,420.0	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	290,899.2	290,899.2
Нийт хөрөнгийн дүн	2,760,146,325.7	2,757,906,360.4	(2,239,965.3)
Богино хугацаат өр төлбөр	6,250,878.8	6,465,073.6	214,194.8
Урт хугацаат өр төлбөр	6,373,679.4	6,373,679.4	-
Эздийн өмч	2,747,521,767.5	2,745,067,607.4	(2,454,160.1)
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,760,146,325.7	2,757,906,360.4	(2,239,965.3)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмч дансууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,756.1 сая төгрөгөөр буурсан нь оффисын талбай худалдан авахад 2,474.1 сая төгрөг төлсөн болон урсгал зардлын төлбөр тооцоо нөлөөлсөн ;
Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 5,774.1 сая төгрөгөөр буурсан нь "Би эм Си Эм" ХХК-тай 2024 онд байгуулсан "Барилга байгууламж худалдан авах" 20240102005

дугаар гэрээний дагуу олгосон урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлээр хааж, холбогдох хөрөнгийг бүртгэлд тусгасантай холбоотой;

- Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу оффисын зориулалттай 7,497.3 сая төгрөгийн барилга, байгууламж, 8.4 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авсантай холбоотойгоор үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,305.4 сая төгрөгөөр нэмэгдсэн
- Хойшлогдсон татварын хөрөнгө 290.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үүссэн татварын түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйд хасагдах орлогын албан татварыг тооцоолон бүртгэснээс шалтгаалсан.
- Богино хугацаат өр төлбөрийн данс 214.2 сая төгрөгөөр өссөн нь Эрдэнэс Монгол ХХК-аас үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор авсан 0412017 тоот гэрээний тайлант жилийн эзэлийн хүү 714.1 сая төгрөгөөр, харилцагч байгууллагуудад өгөх өр төлбөр 50.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан;
- Эздийн өмч дансны үлдэгдэл 2,454.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны 2,618.1 сая төгрөгийн алдагдалаас шалтгаалсан.

Компани нь санхүүгийн magic программ ашилдаг компанийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нийцсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл н

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг/ боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 90 дугаар тогтоолоор Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг баталж, нийт орлогыг 380.0 сая төгрөг, нийт зардлыг 7,593.6 сая төгрөг, татварын өмнөх алдагдал 7,213.6 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант онд 1,047.4 сая төгрөгийн борлуулалтын орлого, 65.1 сая төгрөгийн хүүгийн орлого, 25.6 сая төгрөгийн гадаад валютын ханшийн олз нийт 1,139.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,047.9 сая төгрөгийн зардал гарган, 2,908.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 1,139.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 759.0 сая төгрөгөөр давсан нь 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор баталсан Эрдэнэс оюу толгой ХХК, Оюу толгой ХХК болон "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ-ын хооронд байгуулсан Говийн хөгжлийн талаарх хамтын ажиллагааны хүрээнд "Байгаль орчин, нийгэм, засаглалын түншлэлийн гэрээ"-ний дагуу Оюу толгой ХХК-аас авсан санхүүжилт 790.7 сая төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 65.1 сая төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз 26.5 сая төгрөг зэрэг орлогуудтай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,047.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,545.7 сая төгрөг 46.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт хийгээгүйгээс 1,924.1 сая төгрөг, батлагдсан бүтэц орон тоогоор ажилаагүйгээс 301.8 сая төгрөгийн цалингийн зардал, оффисын байр худалдан авсантай холбоотой 138,524.8 сая төгрөгөөр ашиглалтын зардал тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд цэвэр алдагдал 2,618.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,595.5 сая төгрөгөөр дутуу байгаа нь зардлын дутуу гүйцэтгэлтэй холбоотой байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Тухайлбал:

1. Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 64 дугаар тогтоолоор нийт 31 хүний орон тоо бүтэц баталж, гүйцэтгэлээр 28 ажилтны орон тоогоор ажилласан байна.
2. Эрдэнэс оюу толгой ХХК-ийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн "Хоол унааны нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/12 дугаар тушаалын дагуу нэг хүнд ноогдох өдрийн хоол, унааны зардал 20.0 мянган төгрөгөөр тооцоолж цалингийн зардалд оруулан 155.6 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 119.0 сая төгрөгийг зарцуулсан байна.
3. Тайлант хугацаанд гадаад албан томилолтын зардалд 400.7 сая төгрөг төсөвлөн гүйцэтгэлээр гадаад албан томилолтын зардалд 64.3 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 11.5 сая төгрөг нийт 75.8 сая төгрөгийг зарцуулсан байна.
4. Сургалтын зардалд 27.1 сая төгрөгийг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр компанийн нийт ажилчдыг архив бичиг хэргийн сургалтад хамруулан 0.5 сая төгрөг зарцуулсан байна.
5. Зар сурталчилгаа сонин, сэтгүүл захиалгын зардалд 188.4 сая төгрөг төсөвлөсөн ба гүйцэтгэлээр 305.0 сая төгрөг зарцуулсан байна.
5. Тус газарт төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөөлөгөөг гаргаж батлуулаагүй. Тайлант хугацаанд 44 аж ахуй нэгжтэй 395.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулж ажилласан байна. Тайлант хугацаанд нийт 255.0 сая төгрөгийн нэг төрлийн ажил үйлчилгээний төсөвт өртгийг хуваах замаар 17 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсантай холбоотой албан шаардлага хүргүүлсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрдэнэс оюу толгой ХХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн, 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах, ажилтан нэг бүрийн ээлжийн амралтыг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу биеэр эдлүүлэх өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Ирмүүн Хантайшир аудит" ХХК-ийн ахлах аудитор Б.Норхлоо, аудиторын туслах Д.Отгонсэнгээ нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг менежер Г.Сэр-Од, захирал Д.Бямбацэрэн, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитын менежер Д.Энхдалай газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

"Эрдэнэс оюу толгой" ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн зардлын 6,070.4 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 30.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа хангамжийг хязгаарласантай холбогдуулан албан томилолтын зардлаа бууруулан, сул орон тоог хэвээр хадгалан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд хуулийн дагуу мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд 4,892.5 сая төгрөгийн 73 гүйлгээг байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 завсрын аудитын үр дүн

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулан завсрын аудит гүйцэтгэж, мөнгөн хөрөнгө, авлага бараа материалын дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн 28.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгч, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин нягталж дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 14.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 10.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн, Аудитын шийдвэрийн хэрэгжилт гүйцэтгэлээр 83.3 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д-д	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
		Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	2,085.0	1	2,085.0	100
2	Албан шаардлага	2	2,140.4	1	2,140.4	50
3	Зөвлөмж	3	10,003.3	2	10,003.3	66.7
	Нийт дүн	6	14,228.6	4	12,088.3	83.3

Өмнөх оны аудитаар өгсөн 1 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- “Толгой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд санхүүгийн зохистой харьцаа алдагдсан асуудлыг танилцуулж, компанийн ашигт ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актын төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр авлага үүсгэж, барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг дээд шатны төсөв захирагчийн анхаарах асуудалд шилжүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагч дараах асуудалд анхааралаа хандуулан шийдвэрлүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актын төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, авлага үүсгэж, барагдуулаагүй байна.
- Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор толгой компани буюу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2012-2021 оны хугацаанд авсан үндсэн зээл, хуримтлагдсан хүүгийн төлбөрт 12,022.2 сая төгрөг өр төлбөртэй байгаа нь компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан байгааг анхаарах талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант хугацаанд үндсэн зээл болон хуримтлагдсан хүүгийн төлбөр нь 12,736.3 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 555.3 сая төгрөгийн алдаа¹ илэрсэнд 434.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 120.8 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

5.1. Албан шаардлага

Илрүүлэлт 1: Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор толгой компани буюу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2012-2021 оны хугацаанд авсан үндсэн зээл, хуримтлагдсан хүүгийн төлбөрт 12,022.2 сая төгрөг өр төлбөртэй байгаа нь компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан байгааг анхаарах талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант хугацаанд үндсэн зээл болон хуримтлагдсан хүүгийн төлбөр нь 12,736.3 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор авсан зээл түүний хүүгийн зохистой байдлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлагаа хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 53 ширхэг 111.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудад тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, нэг төрлийн шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх үйлчилгээний нийт 255.0 сая төгрөгийн ажил гүйлгээг 17 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгэж гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний биелэлт, үр дүнгийн нотлох баримт бүрдээгүй, гэрээний хэрэгжилтийн хяналт, баталгаажуулалт хангалтгүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Төсөвт өртгийн хязгаарыг баримтлаагүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 4: Иргэн З.Базаргүртэй 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд санхүүгийн зөвлөх, хуулийн зөвлөх, аман орчуулгын үйлчилгээ үзүүлэх 3 тусдаа гэрээг нэг цагийн хөлсийг 630.8 мянган төгрөгөөр тооцон нийт 67.6 сая төгрөгийн үнийн дүнтэйгээр байгуулсан байна. Эдгээр гэрээг зах зээлийн жишиг үнэтэй харьцуулахад харьцангуй өндөр үнээр байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.2. Зөвлөмж

1. Компанийн дүрэмтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор "Эрдэнэс оюу толгой" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчлэн баталсан дүрмийн 1.2.1-д Компанийн зорилго нь Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий "Оюу толгойн ашигт малтмалын ордод үйл ажиллагаа явуулах, "Оюу Толгой" ашигт малтмалын ордоос хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино, 1.2.3-д "Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ гэж заасан" нь компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлтэй нийцээгүй.

Энэ нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг", компанийн үйл ажиллагаа нь дүрэмтэй нийцэхгүй улмаар дүрмээр хүлээсэн үүргийг хэмжих үнэлэх боломжгүй болох.

Өгсөн зөвлөмж: Компанийн дүрэмд тусгасан зорилго, үйл ажиллагааны чиглэлийг холбогдох хууль тогтоомж, компанийн эрх зүйн статус, бодит үйл ажиллагааны чиглэлтэй нийцүүлэн дахин хянаж, шаардлагатай өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр баталгаажуулах.

2. Дунд хугацааны төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Компани нь 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй байна.

Энэ нь Компанийн үйл ажиллагаа бодлого, төлөвлөлт, алсын хараа, эрхэм зорилго, тодорхой бус байх. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7-д "төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн

болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцээгүй;

Өгсөн зөвлөмж: Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Дансны өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Компани нь өмнөх онд үүссэн 33.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өглөг үүсгэсэн, тайлант хугацаанд 50.0 сая төгрөгөөр тус өр төлбөрийг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна. 20 дугаар зүйлийн 20.2.6-дэд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн өглөгийн үлдэгдлийг барагдуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах, цаашид өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах дотоод хяналтыг сайжруулж, шинэ хугацаа хэтэрсэн өглөг үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилтны ээлжийн амралтын мөнгийг цалинтай давхардуулж 12 ажилтанд нийт 36.9 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Ажилтан нэг бүрийн ээлжийн амралтыг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу биеэр эдлүүлэх, цаашид ижил төрлийн алдаа, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор цалин, олговор тооцох, баталгаажуулах шат дамжлагын дотоод хяналтын тогтолцоог сайжруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				/мянган төгрөгөөр/
			Зөвлөмж		Албан шаардлага		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	"Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн дүрмийн 1.2.1, 1.2.2, 1.2.3-д тусгасан заалтууд нь компанийн үйл ажиллагааны чиглэлтэй нийцээгүй, компани нь дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй гэж дүгнэх нөхцөлийг бүрдүүлсэн	1	-	1	-	-	-
2	Компани нь 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй байна.	1	-	1	-	-	-
3	Компани нь өмнөх онд үүссэн 33,860.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн өглөг үүсгэсэн, тайлант хугацаанд 50,000.0 мянган төгрөгөөр тус өр төлбөрийг нэмэгдүүлсэн байна.	1	83,860.0	1	83,860.0	-	-
4	Ажилтны ээлжийн амралтын мөнгийг цалинтай давхардуулж 12 ажилтанд нийт 36,976.5 мянган төгрөгийг олгосон байна.	1	36,976.5	1	36,976.5	-	-
5	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 53 ширхэг 111,881.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байна.	1	111,881.8	-	-	1	111,881.8
6	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, нийт 285,000.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг 12 цахим сайт, 7 телевиз нийт 19 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хийж, 17 аж ахуй нэгжтэй гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй гэрээний хэрэгжилт тодорхой бус байна.	1	255,000.0	-	-	1	255,000.0

7	Иргэн З.Базаргүртэй 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд санхүүгийн зөвлөх, хуулийн зөвлөх, аман орчуулгын үйлчилгээ үзүүлэх 3 тусдаа гэрээг нэг цагийн хөлсийг 630.8 мянган төгрөгөөр тооцон нийт 67,593.5 мянган төгрөгийн үнийн дүнтэйгээр байгуулсан байна. Уг гэрээнийг зах зээлийн жишгийг үнээс харьцангуй өндөр үнээр байгуулсан байна.	1	67,593.5	-	-	1	67,593.5
8	Компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан байгааг анхаарах талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант хугацаанд үндсэн зээл болон хуримтлагдсан хүүгийн төлбөр нь 12,736,324.3 мянган төгрөг болж нэмэгдсэн байна.	1	-	-	-	1	-
9	Дүн	8	555,311.8	4	120,836.5	4	434,475.3

САГ-2026/97/НА-СТА-ТӨҮГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 856/АД 150053

Улаанбаатар хот

САГ - 2026/97/НА - СТА - 78УГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэн З.Базаргүртэй 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд санхүүгийн зөвлөх, хуулийн зөвлөх, амьн орчуулгын үйлчилгээ үзүүлэх 3 тусдаа гэрээг нэг цагийн хөлсийг 630,800.00 төгрөгөөр тооцон нийт 67,593,500.00 (жаран долоон сая таван зуун ерэн гурван мянга таван зуун) төгрөгийн үнийн дүнтэйгээр байгуулсан байна. Эдгээр гэрээг зах зээлийн жишиг үнэтэй харьцуулахад харьцангуй өндөр үнээр байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даvtан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийг үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг даvtан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дэлгэрмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 858/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/37/НА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 53 ширхэг 111,881,810.00 (нэг зуун арван нэгэн сая найман зуун наян нэгэн мянган наймаа зуун арван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зөрчмөг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудад тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шаалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор "Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дэлгэрмаа/ нарт двалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ийн
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 857/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/97/НА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, нэг төрлийн шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх үйлчилгээний нийт 255,000,000.00 /Хоёр зуун тавин таван сая/ төгрөгийн ажил гүйлгээг 17 аж ахуйн нэгжтэй байгуулан хийж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний биелэлт, үр дүнгийн нотлох баримт бүрдүүлээгүй, гэрээний хэрэгжилтийн хяналт, баталгаажуулалт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.8-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөвт өртгийн хязгаарыг баримтлаагүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй, авах ажиллагааг зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дэлгэрмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-й хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-264230

Z:\Alban\Shaardlaga\2026\0316\857-93.docx

1526181381



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 859/АМ50053

Улаанбаатар хот

САГ-2026/97/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны зөрдлыг санхүүжүүлэх зорилгоор толгой компани буюу "Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2012-2021 оны хугацаанд авсан үндсэн зээл, хуримтлагдсан хүүгийн төлбөрт 12,022,222,554.00 төгрөгийн өр төлбөртэй байгаа нь компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан байгааг анхаарах талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант хугацаанд үндсэн зээл болон хуримтлагдсан хүүгийн төлбөр нь 12,736,324,376.00 (Арван хоёр тэрбум долоон зуун гучин зургаан сая гурван зуун хорин дөрвөн мянга гурван зуун далан зургаан) төгрөг болж нэмэгдсэн байна. Тодорхой түвшинд хэлцэл хийсэн ч үр дүн гараагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, өлөс, өлөс бөмбөрцөгийн тооцоог хянах, ажил, гүйлгээг зарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шапгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил таслал, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор авсан зээл түүний хүүгийн зохистой байдлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид компанийн үйл ажиллагаа, менежментийг сайжруулж ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Одхүү/, "Эрдэнэс оюу толгой" ХХК-ийн захирлын үүргийн түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ийн
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг